

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шарын гол сумын ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2026/4/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр  
Утас: 7037-3089 Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)

Аудитын менежер У.Батсүрэн  
Утас: 7037-3089 Цахим хаяг: [batsurenu@audit.gov.mn](mailto:batsurenu@audit.gov.mn)

Ахлах аудитор С.Батцэцэг  
Утас: 7037-3089 Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ШАРЫН ГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
М.МӨНХБАЯР ТАНАА

## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 146  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Шарын гол сумын ТЭЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Сангийн яам болон Дархан-Уул аймгийн ЗДТГ хооронд байгуулсан Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжсэн "Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл"-ийн дамжуулан зээлийн өрөнд тус сумын орон нутгийн төсвөөс 444.8 сая төгрөгийг аймгийн төсөв рүү татан төвлөрүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмснээр цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 21.5 хувиар өссөн байна.

4526050300<sup>3</sup>

## **Бусад асуудал**

Төсвийн ерөнхийлөн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 97.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/				
Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,670,905,655.23</b>	<b>1,424,790,107.75</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	654,454,951.03	446,087,640.80
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	580,782,697.38	342,301,964.21
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	373,430,751.82	486,885,454.74
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	45,601,010.00	39,640,010.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	16,636,245.00	109,875,038.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>4,327,236,946.44</b>	<b>6,053,619,844.75</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,327,236,946.44	6,053,619,844.75
39200	Биет хөрөнгө	13	3,904,578,690.30	5,628,732,588.61
39300	Биет бус хөрөнгө		422,658,256.14	424,087,300.00
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	-	799,956.14
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>5,998,142,601.67</b>	<b>7,478,409,952.50</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>141,346,669.80</b>	<b>764,956,683.91</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		141,346,669.80	764,956,683.91
41300	Өглөг		141,346,669.80	764,956,683.91
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>5,856,795,931.87</b>	<b>6,713,453,268.59</b>
51	Засгийн газрын хувь оролцоо		5,856,795,931.87	6,713,453,268.59
51100	Засгийн газрын оруулсан капитал		981,754,783.54	981,754,783.54
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		55,187,200.00	55,187,200.00
51200	Хуримтлагдсан үр дүн		3,974,234,804.47	4,830,892,141.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		845,619,143.86	845,619,143.86
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>5,998,142,601.67</b>	<b>7,478,409,952.50</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	/төгрөгөөр/	
			2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		7,242,264,854.30	7,762,859,370.66
11	ТАТВАРЫН ОРЛОГО		2,995,323,392.22	3,193,094,757.64
110	Орлогын албан татвар		2,708,965,251.23	2,864,174,485.78
113	Хөрөнгийн албан татвар		90,542,529.27	100,350,235.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж		195,815,611.72	228,570,036.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	648,774,682.08	4,569,764,613.02
120	Нийтлэг татварын бус орлого		648,774,682.08	1,948,876,443.02
120003	Торгуулийн орлого		201,915.60	200,037,441.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		80,513,630.88	475,531,936.16
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		30,965,138.50	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		568,059,135.60	1,235,402,441.36
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		-	37,904,624.00
122	Тусламжийн орлого		-	1,287,678,270.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	27,678,270.00
122141	Аймаг, нийслэлээс авсан татаасын орлого		-	1,260,000,000.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		-	1,333,209,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,598,166,780.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	4,745,065,295.25	5,790,928,194.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,745,065,295.25	5,790,928,194.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,167,616,564.75	5,273,093,184.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,553,868,907.95	1,887,586,848.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		192,636,008.54	190,130,725.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,394,939,129.77	1,904,913,385.30
2104	Хангамж, бараа материалын зардал		66,659,685.37	67,270,946.00
2105	Нормативт зардал		74,668,280.44	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		144,292,151.21	189,957,450.00
2107	Томилолт, зочны зардал		7,956,000.00	3,970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		120,373,361.00	322,891,707.59
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		612,223,040.47	706,372,121.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		577,448,730.50	517,835,010.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		2,497,199,559.05	1,971,931,176.64
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,656,800,671.68	1,115,273,839.92
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз		31,848,277.68	31,749,432.92
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал		1,624,952,394.00	1,083,524,407.00
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(1,656,800,671.68)	(1,115,273,839.92)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		840,398,887.37	856,657,336.72

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>6,396,781,696.13</b>	<b>6,804,728,890.97</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,995,323,392.22	3,193,094,757.64
110	Орлогын албан татвар	2,708,965,251.23	2,864,174,485.78
113	Хөрөнгийн албан татвар	90,542,529.27	100,350,235.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	195,815,611.72	228,570,036.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	683,230,983.91	3,611,634,133.33
120	Нийтлэг татварын бус орлого	683,230,983.91	990,745,963.33
122	Тусламжийн орлого	-	1,287,678,270.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	27,678,270.00
122141	Аймаг, нийслэлээс авсан татаасын орлого	-	1,260,000,000.00
123002	ОНХНС-аас шилжүүлсэн орлого	-	1,333,209,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,718,227,320.00	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,370,940,363.65</b>	<b>5,110,234,683.74</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,370,940,363.65	5,110,234,683.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,793,491,633.15	4,592,399,673.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,553,868,907.95	1,887,586,848.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,636,008.54	190,130,725.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,394,939,129.77	1,904,913,385.30
2104	Хангамж, бараа материалын зардал	198,672,506.03	134,754,421.06
2105	Нормативт зардал	340,000.00	4,400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	165,258,912.00	194,383,650.00
2107	Томилолт, зочны зардал	7,956,000.00	3,970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	128,371,491.86	178,560,097.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151,448,677.00	93,700,546.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	577,448,730.50	517,835,010.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>2,025,841,332.48</b>	<b>1,694,494,207.23</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,088,294,180.00</b>	<b>1,801,158,283.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,088,294,180.00	1,801,158,283.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,088,294,180.00	1,801,158,283.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(2,088,294,180.00)</b>	<b>(1,801,158,283.00)</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	101,703,234.46
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-</b>	<b>(101,703,234.46)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(62,452,847.520)</b>	<b>(208,367,310.23)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	716,907,798.55	654,454,951.03
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	654,454,951.03	446,087,640.80

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Данс-ны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,033,665,203.54	845,619,143.86	3,137,112,697.10	5,016,397,044.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,276,780.00)	(3,276,780.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,033,665,203.54	845,619,143.86	3,133,835,917.10	5,013,120,264.50
7	Өмчид гарсан өөрчлөлт	3,276,780.00	-	-	3,276,780.00
9	Тайлант үеийн үр дүн	-	-	840,398,887.37	840,398,887.37
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,036,941,983.54	845,619,143.86	3,974,234,804.47	5,856,795,931.87
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,036,941,983.54	845,619,143.86	3,974,234,804.47	5,856,795,931.87
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,036,941,983.54	845,619,143.86	3,974,234,804.47	5,856,795,931.87
19	Тайлант үеийн үр дүн	-	-	856,657,336.72	856,657,336.72
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,036,941,983.54	845,619,143.86	4,830,892,141.19	6,713,453,268.59

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>5,976,136,500.00</b>	<b>6,072,452,620.97</b>	<b>96,316,120.97</b>	<b>101.6</b>
11	Татварын орлого	3,043,852,900.00	3,193,094,757.64	149,241,857.64	104.9
12	Татварын бус орлого	2,932,283,600.00	2,879,357,863.33	(52,925,736.67)	98.2
120003	Торгуулийн орлого	220,000,000.00	200,037,441.50	(19,962,558.50)	90.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	115,622,400.00	78,444,122.83	(37,178,277.17)	67.8
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	5,491,900.00	7,666,399.00	2,174,499.00	139.6
122	Тусламжийн орлого	2,591,169,300.00	2,593,209,900.00	2,040,600.00	100.0
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	1,260,623,600.00	1,260,000,000.00	(623,600.00)	99.9
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,330,545,700.00	1,333,209,900.00	2,664,200.00	100.2
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,761,682,500.00</b>	<b>6,060,521,215.27</b>	<b>(701,161,284.73)</b>	<b>89.6</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,625,588,800.00	4,183,574,297.81	(442,014,502.19)	90.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,496,156,600.00	4,112,209,297.81	(383,947,302.19)	91.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,606,445,400.00	1,544,375,169.46	(62,070,230.54)	96.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	200,805,700.00	190,130,725.55	(10,674,974.45)	94.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,117,942,600.00	1,904,913,385.30	(213,029,214.70)	89.9
2104	Хангамж, бараа материалын зардал	50,145,900.00	40,422,938.00	(9,722,962.00)	80.6
2105	Нормативт зардал	7,755,000.00	4,400,000.00	(3,355,000.00)	56.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	208,954,700.00	201,544,650.00	(7,410,050.00)	96.5
2107	Томилолт, зочны зардал	6,800,000.00	3,970,000.00	(2,830,000.00)	58.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	170,717,700.00	136,539,643.50	(34,178,056.50)	80.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,589,600.00	85,912,786.00	(40,676,814.00)	67.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,432,200.00	71,365,000.00	(58,067,200.00)	55.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	96,342,200.00	41,485,000.00	(54,857,200.00)	43.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,090,000.00	29,880,000.00	(3,210,000.00)	90.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,799,709,900.00	1,775,243,683.00	(24,466,217.00)	98.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	336,383,800.00	101,703,234.46	(234,680,565.54)	30.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	328,759,988.99		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	340,691,394.69		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>26,267,820.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>26,267,820.00</b>
12213	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>26,267,820.00</b>
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,972,820.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,295,000.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>26,267,820.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>26,267,820.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>24,572,310.00</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	13,262,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,021,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,287,760.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,695,510.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,695,510.00

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 560.4 сая төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, хүлээн зөвшөөрөхдөө ИТХ 4.9 сая төгрөгийн, ЗДТГ 144.5 сая төгрөгийн орлогын дансыг ангилал буруу бүртгэсэн нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 10.42(ж), "Толилуулга", "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайланд "Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө" дансыг бууруулж, "Бусад орлого" дансыг нэмэгдүүлж залруулав.

- Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд "Тулга сувилал" ОНӨААТҮГ-ын 411.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сан, ХХҮГ-ын орлогыг ангилал зөрүүлэн үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн нь УСНББОУС1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан "Төсвийн орлогын эдийн засгийн ангилал", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "ААН-ийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 3 дугаар бүлгийн 1 дэх заалттай тус тус нийцэхгүй, "Ангилал", "Толилуулга" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул үндсэн үйл ажиллагааны орлого /ТӨҮГ/ дансыг бууруулж, НДС-аас санхүүжих орлого, бусад орлогын дансыг нэмэгдүүлж залруулав.

Аудитаар 34.6 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд албан шаардлага хүргүүлэв.

### 3.1 Албан шаардлага

Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд сумын ИТХ-д суудалтай улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс 34.6 сая төгрөгийн дэмжлэг олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Нам дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 10.1.5-д "энэ хуулийн 34.6-д заасан хориглосон этгээдээс хандив, тусламж, санхүүжилт шууд болон шууд бусаар авах", 34 дүгээр зүйлийн 34.6-д "Нам дараах этгээдээс хандив авахыг хориглоно", 34.6.3-т "төрийн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	2	560.4			2	560.4	2	560.4				
ЗДТГ	1	122.9			1	122.9	1	122.9				
Тулга сувилал	1	17.3	1	17.3			1	17.3				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>700.6</b>	<b>1</b>	<b>17.3</b>	<b>3</b>	<b>683.3</b>	<b>4</b>	<b>700.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/сая төгрөгөөр/			
									Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТЕЗ	1	34.6			1	34.6						
ЗДТГ	2	4.2	1	3.5			1	0.7				
Тулга сувилал	1	3.3					1	3.3				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>42.1</b>	<b>1</b>	<b>3.5</b>	<b>1</b>	<b>34.6</b>	<b>2</b>	<b>4.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/сая төгрөгөөр/			
									Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
ЗДТГ	1	133.2					1	133.2				
ОНХС	1	1,150.9							1		1,150.9	
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,284.1</b>					<b>1</b>	<b>133.2</b>	<b>1</b>		<b>1,150.9</b>	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
<b>Дүн</b>												
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>1,284.1</b>					<b>1</b>	<b>133.2</b>	<b>1</b>		<b>1,150.9</b>	